Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ЛАБОРАТОРИЙН ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН АЗАР ОВОГТОЙ БАРХАСЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дуусан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Эрүүл мэндийн байгууллагын оношилгоо, лабораторийн тусламж, үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг зохион байгуулна.							
1.	Арга хэмжээ №1.1. Нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэж, нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг хянах тогтолцоог бүрдүүлнэ.	Сүлжээнд нэгдсэн эмнэлгийн тоо-56	50 эмнэлэг сүлжээнд нэгдсэн.	10 эмнэлэг сүлжээнд нэгдсэн байна.	Монгол Улсын хэмжээнд 2024 оны байдлаар нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэх ажлын хүрээнд WHONET үндэсний сүлжээнд өргөжүүлж, 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, 9 дүүргийн нэгдсэн эмнэлэг, 14 төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, 2 амаржих газар, 10 хувийн лаборатори зэрэг нийт 56 лаборатори хамрагдсан.	2024.01.01 2024.12.01	70
2.	Арга хэмжээ 1.2. Эмнэлзүйн лабораторийн шинжилгээний лавлах хязгаар тогтоох зааврын төсөл боловсруулж, батлуулна.	Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийн тоо-1	-	Эмнэлзүйн лабораторийн шинжилгээний лавлах хязгаар тогтоох зааврын төслийг боловсруулж, батлуулна.	Эмнэлзүйн лабораторийн шинжилгээний лавлах хязгаар тогтоох зааврын төслийг боловсруулсан.	2024.01.01 2024.12.01	30

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 2. Эмнэлзүйн болон эрүүл зүйн лабораторийн тусламж, үйлчилгээний чанарын дотоод, гадаад хяналт, үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангана.							
3.	Арга хэмжээ 2.1. Чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрийн нэгдсэн судалгаа хийнэ.	Судалгааны тайлангийн тоо-1	-	Судалгаа хийгдсэн байна.	ЭМЯ, Монголын эрүүл мэндийн лабораторийн ажилчдын холбоотой хамтран Чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрийн нэгдсэн судалгааг 2024 оны 02-11 дүгээр сарын хугацаанд хийж гүйцэтгэсэн. Манай оронд хэрэгжиж буй чанарын гадаад үнэлгээний 7 хөтөлбөрийн 4 нь гадаад улсын, 2 нь үндэсний хэрэгжүүлэгчтэй (ХӨСҮТ, ЦССҮТ) байна. MEQAS хөтөлбөр манай оронд 2008 оноос хэрэгжиж эхэлсэн бол RIQAS болон Prevecal 2017 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна. Олон улсад хамгийн олон оролцогчтой хөтөлбөр болох Их Британий Randox компаний RIQAS хөтөлбөр нь нийт 139 улсын лабораторид чанарын үнэлгээний үйлчилгээ үзүүлдэг бол Канад Улсын Oneworld Accuracy (1WA) хөтөлбөрт 129 улсын лаборатори оролцдог байна. ЦССҮТ-өөс хэрэгжүүлдэг Иммунгематологийн үндэсний чанарын гадаад үнэлгээний	2024.01.01 2024.12.01	50

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					хөтөлбөрөөс бусад бүх 6 хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагууд үйл ажиллагаагаа ISO/IEC 17043:2010 стандартын шаардлагуудыг ханган хэрэгжүүлж итгэмжлэгдсэн байна. Монгол Улсад хамгийн олон оролцогчидтой хөтөлбөр нь MEQAS (233 лаборатори) болон үндэсний хоёр хөтөлбөр ХӨСҮТ-ийн ҮЧГҮХ (чиглэлээс хамааран 170-200 лаборатори) ба ЦССҮТ-ийн ИГҮЧГҮХ (105 лаборатори) байв. Харин оролцогч лабораториудад санал болгож буй хяналтын багцын тооны хувьд RIQAS (38 багц) болон 1WA (15 багц) хөтөлбөрүүд тэргүүлж, үүнтэй холбоотой оролцооны үнэ ч мөн уг хоёр хөтөлбөрийнх хамгийн өндөр (RIQAS хяналтын давтамж болон үзүүлэлтийн тооноос хамаарч жилд 1.5-10.0 сая төгрөг, 1WA жилд 0.77 сая төгрөг) байна. Ихэнх хөтөлбөрүүд хяналтыг жилд 2 удаа явуулдаг, харин олон улсын 3 хөтөлбөр (1WA, Prevecal ба RCPAQAP) зарим нийтлэг чиглэлээр сар бүр хяналтыг хэрэгжүүлдэг байна.		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					Хяналтын шинжилгээний нийт хугацаа (хяналтын сорьц хүлээн аваад шинжилгээний үр дүнг явуулах хүртэл хугацаа) 2-3 долоо хоног байдаг ба оролцогч лабораториуд хяналтын шинжилгээний үр дүнг тухайн хөтөлбөрийн цахим хуудсанд өөрсдөө оруулдаг байна. Мөн олон улсын хөтөлбөрийн төлөөлөгчийн газраас болон үндэсний хэрэгжүүлэгчээс оролцогч лабораториудад заавар өгдөг бол техникийн асуудлаар хэрэгжүүлэгч багтай цахимаар харьцаж зөвлөгөө авах боломжтой байдаг. Харин үндэсний 2 хөтөлбөр (ҮЧГҮХ ба ИГҮЧГҮХ), MEQAS болон Prevecal-ын багаас оролцогчдод зориулан сургалт явуулах эсвэл ажлын байран дээр зөвлөгөө өгөх үйл ажиллагаа хэрэгжүүлдэг байна. Манай улсад хэрэгжиж буй эмнэлгийн лабораторийн чанарын гадаад үнэлгээний 7 хөтөлбөрийн хамрах хүрээ, хяналтын үйл явц хангалттай байна. Цаашид лабораториудын		

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					хийж гүйцэтгэдэг шинжилгээний аль болох олон төрлийг хамруулах, хот болон орон нутгийн бүх түвшний лабораториуд оролцох боломжийг хангах зорилгоор олон улсын болон үндэсний чанарын гадаад үнэлгээний чанартай хөтөлбөрүүдийн өргөн сонголттой болох нь чухал юм.		
Зорилт 3. Эмнэлзүйн шинжилгээний технологийн хяналт, үнэлгээ, урвалж, оношлуур, дагалдах хэрэгслийн чанар, аюулгүй байдал, хангамж, хүртээмжийг дээшлүүлнэ.							
4.	Арга хэмжээ №3.1. Лабораторийн оношлуур, хэрэгслийн бэлэн байдлыг тасралтгүй хангана.	Нийт оношлуурын тоо	-	Нийт хангагдах ёстой оношлуурын 50% хангасан байна.	ЭМЯ-ны ТНБД-ын 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/73 дугаар тушаалаар Бодит хугацааны полимеразын гинжин урвалын шинжилгээний ялгах цомог оношлуур, түргэвчилсэн оношлуур /Нийт 311 сая төгрөг/-ыг төв эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвд хуваарилсан.	Тухай бүр	100
Зорилт 4. Параклиникийн тусламж, үйлчилгээ, цусны аюулгүй байдлыг хангана.							
5.	Арга хэмжээ 4.1. Донорт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах журмыг шинэчилнэ.	Батлагдсан журам-1	Эрүүл мэндийн сайдын 2015 оны 194 дүгээр тушаалаар	Журмыг шинэчлэн батлуулсан байна.	ЭМС-ын "Журам шинэчлэн батлах тухай" 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/207 дугаар тушаалаар "Цусны байнгын болон амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн	2024.01.01 2024.05.27	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
			зохицуулаг даж байна.		үзлэгт үнэ төлбөргүй хамруулах журам" батлагдсан. Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 6830 дугаарт бүртгэгдсэн. ЭМБ-д ЭТҮГ-ын даргын "Тушаал хүргүүлэх тухай" 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 5/2256 тоот албан бичгээр хүргүүлсэн.		
6.	Арга хэмжээ №4.2. Зонхилон тохиолдох өвчний үед цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх заавар, цус сэлбэх үйл ажиллагаанд мөрдөх аргачлалыг шинэчлэн боловсруулж, батлуулна.	Батлагдсан заавар-1	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/03 дугаар тушаалаар зохицуулаг даж байна.	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/03 дугаар тушаал шинэчлэгдэн батлагдсан байна.	ЭМС-ын "Заавар шинэчлэн батлах тухай" 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/256 дугаар тушаалаар "Зонхилон тохиолдох өвчний үед цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх заавар"-ыг нэгдүгээр, "Цус сэлбэх үйл ажиллагаанд мөрдөх аргачлал" батлагдсан. ЭМБ-д ЭТҮГ-ын даргын "Тушаал хүргүүлэх тухай" 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 5/2461 тоот албан бичгээр хүргүүлсэн.	2024.01.01 2024.06.05	100
7.	Арга хэмжээ №4.3. Цусны донорын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн ажиллах журмыг боловсруулан батлуулна.	Боловсруул-агдсан тушаалын төсөл-1	-	Цусны донорын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн ажиллах журмын төслийг	Цусны донорын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан байгуулах, сангийн ажиллах журмын төслийг боловсруулсан.	2024.01.01 2024.12.01	30

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
				боловсруулсан байна.			
8.	Арга хэмжээ №4.4. Дэлхийн цусны өдрийг тэмдэглэх, сурталчилна.	Сурталчилгааны тоо-16 Сурталчилгаанд хамрагдагсдын тоо-92,945	-	Иргэдийн цус, цусан бүтээгдэхүүний талаарх боловсрол нэмэгдсэн байна.	- Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв пэйж хуудсанд 27 эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмжийг байршуулж 42000 хандалт авсан. - "Донор та баатар" групп хуудсанд 16 эрүүл мэндийн зөвөлгөө байршуулан 13600-аар гишүүнчлэлийнхээ тоог нэмэгдүүлсэн. - "Эмч, сувилагч зөвлөж байна" зөвлөгөөний буланд мэдээлэл өгч 31215 иргэдэд мэдээлэл хүргэсэн байна. - Цусны донорын өдөрлөг зохион байгуулахдаа "Цусны донорын хооллолт"-ын зөвлөмж боловсруулан 2500 ширхэгийн хэвлэн түгээсэн. - Их дээд сургууль, байгууллага хамт олон, ЕБС, сайн дурын идэвхтэнүүдэд "Эрүүл аж 5 зарчим", "эрт илрүүлгийн ач холбогдол", "Стрессээс өөрийгөө хамгаалах арга" сэдвүүдээр нийт 380 төрийн албан хаагч, 260 сайн дурын идэвхтэн, 1280 оюутан 320 сурагчдад танхим, онлайнаар сургалт зохион байгуулсан.	2024.01.01 2024.06.14	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
					- ЭМЯ, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил" ажлын хүрээнд Сүхбаатарын талбайд зохион байгуулсан өдөрлөгт оролцон иргэд, донорууд цусны донорын сурталчилгааг нийт 300 гаруй хүнд өгч ажилласан. - Олон улсын хүмүүнлэгийн өдрөөр "Цусны донор" өртөө ажилуулан 590 гаруй иргэдэд мэдээлэл хүргэсэн. - Цусны донорын Дэлхийн өдөр Амьдрал бэлэглэсэн 20 жил: Цусны донор танд баярлалаа" уриан дор БЗД-ийн "Жанжин" клубт 2024.06.14-нд зохион байгуулагдлаа. Өдөрлөгийн үеэр 10 төрлийн контент видео, шторк, сурталчилгааны материал түгээж, 500 гаруй иргэдэд хүргэсэн.		
Нэмэлт ажил:							
9.	Багийн эмч нарын зөвлөгөөн зохион байгуулахад оролцоно.	Багийн эмчийн үзлэгийн тайлан-2	-	Багийн эмч нарын зөвлөгөөнд оролцсон эмч нарыг урьдчилан сэргийлэх үзлэгт	Монгол-Японы эмнэлэгт 2024 оны 10 дугаар сарын 18, 20-ны өдрүүдэд нийт 72 багийн эмч эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдсан.	2024.10.01 2024.10.31	100

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
				хуваарийн дагуу хамруулсан байна.			

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
9.	Арга хэмжээ 1. Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдана.	Суралцсан кредит цаг-9 багц цаг	-	8 кредит цаг	Төрийн захиргааны Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн тул Удирдлагын академийн захирлын 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн А/119 тоот тушаалаар сертификат олгов. Сертификат №А4597	2023.10.01 2024.02.25	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЭТҮГ-ын ЭТЧАБХ-ийн мэргэжилтэн
(Албан тушаал)

А. Бархас / А.Бархас /
(Нэр, гарын үсэг)

2024.12.05
(Огноо)

105